

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР



Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүн, үр ашиг, Засгийн газрын векселийн үр дүн



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ
УДААШИРАЛТАЙ, ГЭРЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНД ТАВИХ
ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**



АЛТАЙ ХОТ 2017 ОН

Тайланг бэлтгэсэн:Говь-Алтай аймгийн Аудитын
газрын II баг

Дарга, Тэргүүлэх аудитор

Х.Түвшинбаяр

Аудитын менежер

Д.Эрдэнэчимэг

Ахлах аудитор

Д.Цэрэнханд

Ахлах шинжээч

Э.Сүнжидмаа

Шинжээч

Х.Билэгбаяр

2017 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70483413,
70484030 дугаарын утас,
70483413 дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум Баянхайрхан
баг, Аудитын газар

АГУУЛГА

Аудитын зорилт, арга зүй, стандартыг талаарх
мэдэгдэл.....
Аудитад ашигласан шалгуур.....
Товчилсон үгийн тайлбар.....
Ерөнхий мэдээлэл.....

Бүлэг нэг.

А. Эрх шилжин ирсэн ажлуудын 50 хувь нь магадлал эксперт хийлгээгүй зураг төсөө үндэслэн үйл ажиллагаа явуулж байна.

Б. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

В. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын ажлын явц удааширалтай, түүнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

Бүлэг хоёр

ТАЙЛБАР: БҮЛЭГ-II Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээгээр хийгдсэн хөрөнгө оруулалт байхгүй тул тайлан, дүгнэлт бичих боломжгүй байна.

Бүлэг гурав.

А. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь аймаг орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа бодлоготой уялдаагүй байна

Б. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

В. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын 95% нь бүрэн хэрэгжиж дууссан байна.

Бүлэг дөрөв.

А. Векселиэр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний сонголт оновчтой бодитой төлөвлөгдсөн эсэхийг үзэх боломжгүй байна.

Б. Векселиэр олгосон санхүүжилт, барилга угсралтын ажлын гүйцэтгэл бодитой, төлбөрийн эргэн төлөлт үндэслэлтэй байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн тэргүүлэгчдийн хурал
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
СТС	Санхүү төрийн сан
САХ	Соёл амралтын хүрээлэн
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УИХ	Улсын их хурал
ТБОНӨБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

**АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ,
БҮРЭН ЭРХ****АУДИТЫН ЗОРИЛТ****АУДИТЫН ХАМАРСАН
ХҮРЭЭ****АУДИТЫН АРГА ЗҮЙ
СТАНДАРТЫН ТАЛААРХ
МЭДЭЭЛЭЛ****АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, ХАМАРСАН
ХҮРЭЭ, БЭРХШЭЭЛ**

Аудитыг Улсын их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн, ҮАГ-ын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газар хийж гүйцэтгэлээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв.

❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

❖ Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээ үр дүн, үр ашигтай хэрэгжсэн эсэх

❖ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

❖ Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

Аудитаар Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох байгууллага болон улс орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хүрээнд шалгалаа.

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000-3100, Төрийн хяналт шалгалтын стандарт баримтлана.. гүйцэтгэлийн аудитын гарын авлагад дурьдсан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, лавлагаа авах, зарцуулалтын баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх, газар дээрх нөхцөл байдалтай танилцаж фотожуулах үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг арга зүйг ашиглаж аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, холбогдох шийдвэрийн санал боловсрууллаа. 2016 онд шинээр эхэлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хувийн хэргийг шинээр бүрдүүлэх бөгөөд өмнөх оноос дамжин ирсэн объектын хувьд хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлтийг хийв.

ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг **"ДУНД"** гэж үнэлэв.

АУДИТЫН СТАНДАРТЫН ТАЛААРХИ МЭДЭГДЭЛ

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчилөлт
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Иргэний тухай хууль
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам"
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"
- Дээрхи хуулийг хэрэгжүүлсэнтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт стандарт

АУДИТЫН ХУГАЦАА**АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Аудитыг 2017 оны 03 дугаар сарын 25-наас эхлэж 04 дүгээр сарын 19-ны өдөр дуусгаж Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүллээ.

Аудитыг аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн стандартыг хангуулж, УОНТХО-ыг гүйцэтгэлийн багийн Ахлах шинжээч Э.Сүнжидмаа, шинжээч Х.Билэгбаяр, Засгийн газрын векселийн үр дүнг Ахлах аудитор Д.Цэрэнханд нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын шийдвэр болон хавсралт хэсгүүдээс бүрдсэн.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 4 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өглөө.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох удирдлагуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:**

- ✚ Тайланд онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймагт 29 ажил хэрэгжиж байгаагаас 21 ажлын эрх шилжин ирсэн байна. Дээрхи ажлуудад гэрээний дагуу 11,753.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 10,319.17 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 1,434.23 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.
- ✚ Худалдан авах ажиллагааны албанд 20 ажилд тендер шалгаруулж төсөвт өртгөөс 249.2 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.
- ✚ Эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын 21 ажлаас 17 ажил нь бүрэн хэрэгжиж дууссан байна. Харин 4 ажил гүйцэтгэл 70 хувийн хэрэгжилттэй байна.
- ✚ Улсын төсвөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд нь аймаг орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа хэдий ч түүний ажлын явц хэтэрхий удааширалтай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:

- ✚ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг аймгийн ИТХ-аас 2 удаа тодотгол хийж төсөл арга хэмжээнүүдийг батласан байна.
- ✚ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 32 ажлыг 1,705.8 сая төгрөгөөр санхүүжүүлснээс 7 ажил нь өмнөх онд хийсэн ажил байна. Тайланд онд хэрэгжсэн 25 ажлаас 4 ажил нь урсгал зардал хэлбэрээр санхүүжүүлж 21 ажлын бодит гүйцэтгэл болон бусад баримт материалыг тулган үзлээ. Хийгдсэн хөрөнгө оруулалтын 95 хувь бүрэн хийгдэж хүлээн авч ашиглаж байна.

БҮЛЭГ-I УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН, ҮР АШИГ

Бүлэг 1: Эрх шилжин ирсэн ажлуудын 50 хувь нь магадлал эксперт хийлгээгүй зураг төсөв үндэслэн барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын 2016 Төсвийн тухай хуулиар Говь-Алтай аймагт 53,454.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл арга хэмжээг баталсан байна.

Төсвийн тухай хуульд тусгагдан хэрэгжиж байгаа 34 төсөл, арга хэмжээний 22 ажил аймагт эрх шилжиж ирсэн, 12 ажлын эрх шилжиж ирээгүй байна. /Хавсралт №1/

Аудитаар төсөл арга хэмжээнүүдийн үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг судалж үзэхэд 22 төсөл арга хэмжээ нь аймгийн хөгжлийн цогц бодлого, үндсэн чиглэл, орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий ажлын жагсаалтад орсон байна.

Дээрх эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийн баримт материалыг үзэхэд газар эзэмших гэрчилгээ болон техникийн нөхцөл байдлын бүрэн тусгаж баримтжуулан ажилласан байна.

Аймагт эрх шилжин ирсэн 12 барилгын ажлын зураг төсөвт магадлал хийсэн байдлыг үзэхэд Барилгын тухай хуульд заасны дагуу зураг төсөв боловсруулан Барилгын хөгжлийн төвөөс магадлал хийсэн 9 ажил байна. Харин 1,956.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 барилгын зураг, төсөвт магадлал хийгдээгүй байна¹ /Хавсралт №2/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх нь шилжиж ирсэн болон эрх нь шилжиж ирээгүй хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт орсон эсэхийг давтан тооцож үзэхэд:

Эрх нь шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын хувьд:

Хүүхэд залуучуудын ордны барилгын ажил нь Төсвийн тухай хуулиар 962.7 сая төгрөгөөр төсөвт өртгийг нэмэгдсэн, 2016 оны төсвийн тухай хуулиар эрх шилжиж ирсэн Тайшир сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга нь 550.0 сая төгрөгөөр төсөвт өртөг нь батлагдсан байна. Барилгын хөгжлийн төв нь 2016 онд тус барилгын зураг төсөвт магадлал хийж 857.9 сая төгрөгөөр баталгаажуулж төсөвт өртгийг 307.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тус барилгын төсөвт өртөгийг нэмэгдүүлэх талаар аймгийн Засаг дарга Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газарт хүсэлт уламжлан, гүйцэтгэгчтэй дахин гэрээ байгуулан ажиллаж байна.

¹ Барилгын тухай хуулийн 13.2, 13.3-т заасны дагуу барилгын норм, нормативын баримт бичгийг баримтлан боловсруулж, магадлал хийсэн зураг төслөөр баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх хуулийн этгээдэд барилгын ажил эхлүүлэх, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг/ 13.5-ын "... зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно, Төсвийн тухай хуулийн 29.4-ийн "Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хууль заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

Эрх нь шилжиж ирээгүй хөрөнгө оруулалтын хувьд:

Эрх шилжиж ирээгүй 12 ажлын төсөвт өртөгийн өөрчлөлтийг 2008-2015 онуудын Төсвийн тухай хуульд заасан төсөвт өртөгтэй харьцуулан үзэхэд: Тайшир сумын Соёлын төвийн барилгын ажил анх батлагдсан төсвөөс 737.4 сая төгрөгөөр нэмэгдэж 1,087.4 сая төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтанд хүлээлгэн өгсөн, Баян-Уул сумын 640 хүүхдийн хичээлийн барилгын ажил анх батлагдсан төсөв өртөгөөс 1,981.6 сая төгрөгөөр, Есөнбулаг сумд баригдаж байгаа 50 ортой төрөх эмнэлэгийн барилгын ажил 948.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдэн анх батлагдсан төсөвт өртөгөөс 3,667.9 сая төгрөгөөр өсч батлагдсан байна. Хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж санхүүжүүлэхгүй байгаагаас он дамжин удааширсан нь төсөвт өртөг нэмэгдэх шалтаан болжээ.

Бүлэг 2: Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд сайдын багцаас эрх шилжиж ирсэн 22 ажлаас аймагт 2016 онд эрх нь шилжин ирсэн Хүүхэд залуучуудын ордны барилгын ажилд тендер шалгаруулах шаардлагагүй тул, 21 ажилд Орон нутгийн өмчийн газар нь үнэлгээний хороо байгуулан, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар-20 ажил, түлхүүр гардуулах шууд гэрээгээр -1 ажлыг зохион байгуулсан байна. Уг 21 ажил нь 13,815.5 сая төгрөгийн өртөгтэй бөгөөд тендер шалгаруулж 13,566.3 сая төгрөгөөр гэрээ байгууллан 249.2 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж ажилласан байна. Хэмнэгдсэн төсвийг ямар нэгэн төсөл арга хэмжээнд зарцуулагдаагүй улсын төсөвт үлдсэн байна. /Хавсралт№3/

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад төсөл арга хэмжээний санхүүжилтээр хийгдэх ажлуудад тендер шалгаруулалтыг хийхдээ тендерийн урилгыг өдөр тутмын Зууны мэдээ сонин болон www.e-procurement.mof.gov.mn, www.govi-altai.gov.mn, www.meps.gov.mn вэб сайтуудад тендерийн урилга болон баримт бичгүүдийг нийтэлж ажилласан байна.

Худалдан авах ажиллагаа нь зарлагдсан төсөл арга хэмжээний нэр, зориулалтыг өөрчилөөгүй, хугацаа алдаагүй байна. Тендерийн үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулжээ.

Бүлэг 3: Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын ажлын явц удааширалтай, түүнд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд эрх шилжиж ирсэн 22 ажлыг 16,753.4 сая төгрөгийн төсөвт өртөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн ТАХ-ний жагсаалт, санхүүжил олгосон байдал:

Хүснэгт №1

№	Төсөл арга хэмжээний нэр	Хийх ажил гэрээний үнэ	Олгосон санхүүжилт				Дутуу+, илүү-
			Санхүүжилт Аймгийн төрийн сангаас олгосон	Вексел олгосон	Хөгжлийн банкнаас	Нийт олгосон санхүүжилт	
1	Цэцэрлэгийн барилга /Говь-Алтай, Бигэр сум/	1,027.00	1,020.40			1,020.40	6.60
2	Тайшир сумын 75 ортой хүүхдийн цэцэрлэг	857.90	537.40			537.40	320.50
3	Алтай сумын 240 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга	1,350.00	974.00	130.00		1,104.00	246.00
4	Төгрөг сумын 100 хүүхдийн цэцэрлэг	924.60	918.10			918.10	6.50
5	Тонхил сумын 100 хүүхдийн цэцэрлэг	1,032.00	957.20			957.20	74.80
6	Соёл амралтын хүрээлэн	998.80	999.80			999.80	(1.00)
7	Соёл амралтын хүрээлэн багц 1	335.60	322.70			322.70	12.90
8	Соёл амралтын хүрээлэн багц 2	286.60	275.40			275.40	11.20
9	Соёл амралтын хүрээлэн багц 3	176.00	75.40			75.40	100.60
10	Соёл амралтын хүрээлэн багц 4	100.40	100.40			100.40	-
11	Соёл амралтын хүрээлэн багц 5	68.40	67.30			67.30	1.10
12	Цогт сумын Баянтоорой тосгоны 100 хүүхдийн дотуур байр	990.00	618.67	281.00		899.67	90.33
13	Чандмань сумын ЭМТ-ийн барилгын өргөтгөл	158.40	158.40			158.40	-
14	Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажил	69.40	69.40			69.40	-
15	Хөх морьт сумын ЭМТ-ийн барилгын засварын ажил	68.60	68.60			68.60	-
16	Бугат сумын ЭМТ-ийн барилгын ажлын засвар	154.00	154.00			154.00	-

17	Дэлгэр сумын Гуулин тосгоны эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажил	49.50	49.50			49.50	-
18	ГАА-ийн ЗДТГ-д тоног төхөөрөмж нийлүүлэх	99.70	99.70			99.70	-
19	Хүүхэд залуучуудын ордны барилга	2,761.90	2,197.20			2,197.20	564.70
20	Хөх морьт сумын Сургуулийн спорт заалны барилгын их засварын ажил	94.70	94.70			94.70	-
21	Гуулин тосгоны спорт заалны барилгын ажил	149.90	149.90			149.90	-
22	Сумын төвийн шинэчлэл төсөл Говь-Алтай дэлгэр сумын шинэчлэл төсөл	5000.0	2,600.00	-	890.57	3,490.57	1,509.43
	Дүн	16,753.40	12,508.17	411.00	890.57	13,809.74	2,943.66

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 17 ажил нь бүрэн хэрэгжиж 5 ажил нь хэрэгжээгүй байна. /Санхүүжилттэй холбоотой мэдээлэлийг дээрх хүснэгт №1 нээс харах боломжтой/

Эрх нь шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэлийг үзэхэд дараах байдалтай байна.

Тайшир сумын 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын талаар:

“Шатат” ХХК нь 2016 оны 06 дугаар сарын 09-ны өдрөөс 2016 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүртэл Тайшир сумын 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг хийж гүйцэтгэхээр 531.6 сая төгрөгөөр гэрээ байгуулан 2016 онд эксперт, магадлал хийлгэсэн байна. Анх байгуулсан гэрээний дүнгээс 326.3 сая төгрөгөөр төсөвт өртөгөө нэмэгдүүлэн гэрээний хугацааг 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдөр хүртэл сунгалт хийж дахин гэрээ байгуулсан байна. ажлын гүйцэтгэл 64 хувь байна.

Хүүхэд залуучуудын ордны барилгын ажлын талаар:



“Арвин Бэлт” ХХК нь 2011 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 01 дуусахаар 1,799.2 сая төгрөгөөр уг барилгын ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна. 2016 оны Төсвийн тухай хуулиар 962.7 сая төгрөгөөр төсөвт өртөгөө нэмэгдүүлэн 2017 оны 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэл дахин гэрээг сунгасан байна. барилгын бодит гүйцэтгэл 74 хувьтай байна. Олон жил царцсан тул барилгын цонхнууд хагарсан, хажуу хана руу ус орсон зэргээр чанар байдалд нь сөрөг нөлөө гарч элэгдэлд орж байна

Алтай сумын 240 хүүхдийн Сургуулийн барилгын ажлын талаар:



“Аксу-Алтай” ХХК нь 2015 оны 07 дугаар сарын 14-ны өдрөөс 2016 оны 08 дугаар сарын 28-ны хүртэл 1,350.0 сая төгрөгөөр уг барилгыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан байна. Одоогоор барилгын ажлын гүйцэтгэл 82 хувьтай

санхүүжилтээс 246.0 сая төгрөг дутуу байна. Гэвч гэрээний дагуу барилгын ажлыг ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй гэрээний сунгалт хийгээгүй байна.

Соёл амралтын хүрээлэн байгуулах ажлын багц 3-н талаар:



“Ус-Алтай” ХХК нь 2015 оны 07 дугаар сарын 30-наас 2015 оны 11 дүгээр сарын 10-ны хүртгэл 176.0 сая төгрөгөөр Усан оргилуур барих ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгчийн зүгээс ажлаа чанаргүй хийсэнтэй холбоотой дахин гэрээ хийж 2017 оны 05 дугаар сарын 27 хүртэл сунгасан байхад 100% гүйцэтгэсэн гэж улсын комисс хүлээн авсан байна. Бодит гүйцэтгэлээр ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна. Санхүүжилтийг 100.6 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Дэлгэр сумын шинэ сумын шинэ сумын төслийн хүрээнд:



Дэлгэр сумын төвийн Дэд бүтэц, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, усан хангамж, усан хангамжийн эх үүсвэр дулааны шугам, сүлжээ, уурын зуух, гадна цахилгаан, холбоо, үерийн хамгаалалтын далан, төсвийн байгууллагыг шугам сүлжээнд холбох ажлуудийг хийж гүйцэтгэхээр анх 2014 оны 08 дугаар сарын 19-ны өдөрөөс 2014 оны 11 дүгээр сарын 30-ны хооронд уг ажлыг гүйцэтгэхээр гэрээг “Мандал-Голомт” ХХК-тай байгуулсан байна.

Гэвч гэрээт хугацаандаа ажлыг гүйцэтгээгүй учраас дахин сунгалт хийж 2016 оны 06 дугаар сарын 30-нд багтаан ашиглалтанд оруулна гэж дахин гэрээ байгуулсан байна.

Гүйцэтгэгч одоог хүртэл төсөл арга хэмжээний ажлыг ашиглалтанд өгөөгүй бөгөөд 2014-2016 онуудад 3,497.8 сая төгрөгийн 70 хувийн ажлын гүйцэтгэл гаргаж 3,490.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитаар Дэлгэр сумын төвийн шинэ сумын төслөөр хэрэгжсэн ажлуудыг газар дээр нь очиж үзэхэд бараа материал татсан мөн уурын зуухны барилгын суурь цутгасан, DZL маркын 2.8 мвт-ын хүчин чадалтай 2 ширхэг тогоо суурлуулсан, гадна дулаан, цэвэр шугам 1.65 км, бохирын 1.5 км шугам, цахилгааны 4.3 км шугам, 2.8 км үерийн хамгаалалтын сувгийн ажлууд хийгдсэн ба дээрх ажлын гүйцэтгэл төсөвт өртөгийн талаарх тооцоо судалгааны баримт материалыг гүйцэтгэгч компаний инженер байхгүй мэдэхгүй гэсэн тайлбар өглөө.

Захиалагч аймгийн ГХБХБ-ын газрын зүгээс дээрх ажлууд нь бүрэн хэрэгжиж дуусаагүй ба хэрэгжилт хангалтгүй тул мэргэшсэн төсөвчнөөр хийгдсэн ажлын талаар дахин хянуулж байгаа тул одоогоор хэдэн хувийн гүйцэтгэлтэй ажил хийсэнг нотлох боломжгүй гэсэн тайлбар өглөө.

Мөн гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу гэрээт хугацаа хэтрүүлсэнд 727.5 сая төгрөгийн алданги тооцох боломжтой байна.

Захиалагчийн зүгээс 2014-2016 онуудад 9 удаа хяналт хийсэн байна. Мөн 2016 онд Барилга хөгжлийн төвтэй хамтарсан хяналт хийж тус төсөл арга хэмжээний ажилд магадлалын дүгнэлтгүйгээр ажил гүйцэтгэхгүй байх талаар ажлын журналд ажлыг зогсоох үүрэг өгсөн байна.

Дэлгэр сумын Гуулин тосгоны Эрүүл мэндийн төвийн барилгын ажил:

“Мөрөн Алтай” ХХК 2016 оны 10 дугаар сарын 10 нд хүлээлгэн өгөхөөр уг барилгын засврын ажлыг 49.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Бодит гүйцэтгэлээр: хана хагарч мөөгөнцөртсөн байна. Ажлыг бүрэн гүйцэтгэж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвийн барилгын ажил:

“Мөрөн Алтай” ХХК 2016 оны 10 дугаар сарын 02 нд хүлээлгэн өгөхөөр уг барилгын засварын ажлыг 68.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Бодит гүйцэтгэлээр: гадна талын засвар нь баруун талаасаа хууларсан байдалтай байна.

Бигэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил: :



Бигэр суманд баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн 1,027.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлыг “Айргийн Хад” ХХК хийж гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэгчид 2015-2016 онуудад 1,020.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, 6.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Гэвч Улсын комисс гадна орчны бетон зам, тоглоом болон дотор цэвэр бохирын холболт хийгдээгүй байхад хүлээн авсан байна.

Төгрөг сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил:

Төгрөг сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын тухайд 5 цонх дотор талдаа цууралт өгсөн, таазны хавтан хооронд зааг гарсан зэрэг ажлуудын чанар байдал муу байлаа.

Цогт сумын Баянтоорой тосгоны 100 хүүхдийн дотуур байрны ажил:



Цогт сумын Баянтоорой тосгоны 100 хүүхдийн дотуур байрны барилгын чанар байдалтай танилцахад ханын дотор талын өнгөлгөө хагарсан, мөөгөнцөр үүссэн байна.

Соёл амралтын хүрээлэн багц-4 ажлын хүрээнд:

САХ-н багц 4 ажлын тухайд 4 тоглоом хийснээс морин тойруулгын морь байхгүй мөн 1 алсын харагч байхгүй, тоглоомын чанар шаардлага хангалтгүй байна. Уг ажлын зураг төсвийг “Нарт дизайн” ХХК 2012 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд зураг төсөвт тоглоомыг хэдэн диаметр-тай хэдэн суудалтай урт нь хэд байхыг заагаагүй зөвхөн 4 ширхэг тоглоом гэж тоо ширхэгийг зааж өгсөн байна.

Мөн Соёл амралтын хүрээлэнгийн багц -2 хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг давтан тулгаж үзэхэд: Хогийн сав -16 ширхэг, сандал -29 ширхэг, худалдаа үйлчилгээний саравч-17 ширхэг, харуулын байр-18 ширхэг ажлуудыг дутуу хийгдсэн байхад Улсын комисс хүлээн авсан байна.

Мөн соёл амралтын хүрээлэн байгуулах ажлын хөл бөмбөгийн талбай, гар бөмбөг, теннис, хоккей тэшүүр талбай, сурын талбай зэрэг ажлуудын чанар байдалтай танилцахад гар бөмбөгийн талбайн резинен наалт байхгүй, цементэн талбайн зах хэсгээр хайрга нь гарсан байдалтай байна.

Бусад эрх шилжих ирсэн хөрөнгө оруулалтын ажлуудын бодит гүйцэтгэлийг үзэхэд ямар нэгэн зөрчил илэрсэнгүй.

Захиалагчийн хяналтын зардал: Тайлант онд хэрэгжих дууссан 18 ажлын гүйцэтгэлийг үзэхэд 16 ажлыг бүрэн хүлээн авсан 2 ажлын гүйцэтгэл дутуу байхад улсын комисс хүлээн авсан байна. Дээрх ажлуудаас захиалагчийн хяналтын зардалд 138.95 сая төгрөг олгохоос 57.5 сая төгрөгийн олгож 81.3 сая төгрөгийн хяналтын зардал олгоогүй байна. Үүнээс Төсөл арга хэмжээгээр хийгдэж дууссан соёл амралтын хүрээлэнгийн багц ажлын захиалагчийн хяналтын зардал 33.0 сая төгрөг, Бигэр сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгын 1.6 сая төгрөгийг хяналт тавьсан байгууллагад шилжүүлээгүй байна. Бусад Хийгдэж дуусаагүй ажлын захиалагчийн хяналтын зардал 46.7 сая төгрөг байна.

Эрх шилжих ирээгүй бусад хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэлийн талаар:

Төсвийн тухай хуулиар аймагт эрх шилжиж ирээгүй 36,860.9 сая төгрөгийн өртөгтэй 12 ажил байна. Эрх шилжээгүй ажлуудын дундаж гүйцэтгэл 53 хувьтай байна.

Үүнд: Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/ Тус барилга нь 1,087.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд зураг төсөвт магадлал хийгдэж батлагдсан байна. 2011-2016 онуудад 897.6 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгож үлдэгдэл 189.7 сая төгрөгийг веклээр санхүүжүүлсэн байна. Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай улсын комисс хүлээн авсан байна. Чанар байдлын тухайд цууралт өгсөн, тааз нь тусаал гойжиж будаг нь ховхорсон байдалтай байна.

Эмнэлгийн барилга, 10 ортой /Говь-Алтай, Цээл/ Тус барилга нь 535.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2011-2012 онуудад 435.0 сая төгрөгийн санхүүжилт авч 100.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна. Барилгын ажлын гүйцэтгэл 50-60 хувьтай Чанар байдал: Тухайн барилга бүрэн баригдаж дуусаагүй ба нэг давхарын өргийн ажил хийгдсэн байна. Аудитаар барилгын гадна болон ханын хэмжилт хийж зурагжууллаа.

Төрөх эмнэлэг 50 ортой /Говь-Алтай, Есөнбулаг/ Тус барилга нь 2,898.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2011-2016 онуудад 2,433.0 сая төгрөгийн санхүүжилт

олгож 465.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын ажлын гүйцэтгэл 45 хувьтай байна. Чанар байдал: Тухайн барилга бүрэн баригдаж дуусаагүй байна. Барилгын 1,2 давхарын хамар ханын өргийн ажил хийгдсэн зоорийн давхарын шалны ажил хийгдсэн байна.

Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан /Говь-Алтай/: Тус ажил нь 7,385.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2008-2016 онуудад 4,208.7 сая төгрөгийн санхүүжилт өгч 3,176.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн улсын комисс хүлээн авсан байна. Чанар байдал: ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй болно.

Сургуулийн барилга, 640 суудал /Говь-Алтай, Баян-Уул/: Тус барилга нь 3581.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2010-2016 онуудад 1,946.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,634.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын гүйцэтгэл 100 хувь улсын комисс хүлээн авсан байна. Чанар байдал: Чанар байдлыг үзэхэд дотор дээд таазнаас ус тааз будаг ховхорч унасан байдалтай байна.

"Алтай" чуулгын байр /Говь-Алтай/: Тус барилга нь 5,494.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2008-2016 онуудад 4,967.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 527.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын гүйцэтгэл 100 хувь улсын комисс хүлээн авсан байна. Чанар байдлын тухайд гадна талын хана нэлэнхүүдээ цууралт өгсөнөөс хана төвөйсөн хамгаалалт тавьсан байдалтай байна.

Эмнэлгийн барилга, 10 ор /Говь-Алтай, Дэлгэр/: Тус барилга нь 736.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2012-2016 онуудад 499.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 236.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын гүйцэтгэл 100 хувь улсын комисс хүлээн авсан байна. Чанар байдлын талаар ямар нэгэн зөрчилтэй асуудал үүсээгүй байна.

Аврах гал унтраах ангийн барилга /Говь-Алтай, Алтай/ Тус барилга нь 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2013-2015 онуудад 1,499.71 сая төгрөгийн санхүүжилт олгож, 100.29 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын гүйцэтгэл 55-65 хувийн гүйцэтгэлтэй Чанар байдал: Бүрэн дуусаагүй 3 давхарын өрөг боссон байна.

Бугат сумын сургуулийн барилгын өргөтгөлийн барилга: Тухайн ажил нь 1,586.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд Улсын төсвөөс 2013-2016 онд 958.3 сая төгрөг, 2016 онд векселиэр 459.3 сая төгрөг нийт 1,417.6 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ. Бодит байдал дээр үзэхэд ажлын гүйцэтгэл 85%-90%-тай байна. Чанар байдал: Гадна засвар хийгдсэн одоо дотор заслын ажил хийгдээгүй байна.

Сургуулийн барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум/: Тус барилга 5,426.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2014-2016 онуудад 1,703.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 3,723.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын гүйцэтгэл 50 хувьтай байна. Чанар байдал: Каргаз угсралтын ажил хийгдсэн байна.

Сургуулийн барилга, спорт заал, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь салбар ангаах ухааны сургууль/ Тус барилга нь 5,184.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2013-2016 онуудад 1,046.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 4,138.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Барилгын гүйцэтгэл 50 хувьтай байна. Чанар байдал: Одоо 2 давхарын карказын цутгалтын ажил хийгдсэн байна.

Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Говь-Алтай, Хөхморьт сум/: Тус барилга нь 1,343.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2014-2016 онуудад 1,343.9 сая төгрөгийн

санхүүжилтийг 100 хувь олгосон байна. Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь улсын комисс хүлээн авсан байна. Чанар байдал: Ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй болно. /Хавсралт 4/

Дээрх ажлын гүйцэтгэлийг үзэхэд 19,628.8 сая төгрөгийн 6 ажлыг улсын комисс хүлээн авч ашиглалтанд хүлээлгэн өгсөн байна.

Ашиглалтанд хүлээлгэн өгсөн барилгуудын чанар байдлыг үзэхэд Баян-Уул сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын дотор дээвэр муу хийгдсэнээс таазнаас ус гойжиж ховхорч хууларсан, Ардын дуу бүжгийн Алтай чуулгын тухайд гадна талын хана нэлэнхүүдээ цууралт өгсөн хана товойж нурах магадлалтай тул хамгаалалт тавьсан байдалтай байна.

Ардын дуу бүжгийн Алтай чуулгын барилга



Баян-уул сумын 640 хүүхдийн сургуулийн хичээлийн байр



2011-2016 онуудад Төсвийн тухай хуулиар эрх шилжиж ирээгүй 17,232.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ажлын хэрэгжилт 47 хувьтай байна.

ТАЙЛБАР: БҮЛЭГ-II Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээгээр хийгдсэн хөрөнгө оруулалт байхгүй тул тайлан, дүгнэлт бичих боломжгүй байна.

БҮЛЭГ-III ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН, ҮР АШИГ

Бүлэг 1: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь аймаг орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа бодлоготой уялдаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 сарын 04-ны өдрийн 13 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд анх 678.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж, ИТХ-ын 2016 оны 12 сарын 05-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор 1,776.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг баталж, анх батлагдсан төсөл арга хэмжээг 1,098.3 сая төгрөгөөр нэмж баталжээ. Аймгийн ИТХ-аар ОНТХО-ыг 2 удаа тодотгосон байна.

Дээрхи батлагдсан ажлуудын 30 хувь нь аймгийн үндсэн чиглэл болон аймгийн засаг даргын “Бидний–Алтай” мөрийн хөтөлбөрт багтсан, 70 хувь нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл буюу Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд багтсан ажлууд байна. Хөрөнгө оруулалтын ажлууд нь аймгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа хэдий ч аймаг орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа бодлоготой уялдаагүй байна². /Хавсралт 5/

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тайлант онд Халиун сумын Олонбулаг багийн төв, Шарга сумын Улаантуг багийн төв, Цогт сумын Далан багийн төвийн барилгын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн бөгөөд газар эзэмших гэрчилгээ олгоогүй байна. Энэ нь сумын Засаг даргын газар эзэмшүүлэх төлөвлөгөө, захирамжид хамаараагүй учраас олгогдоогүй байна³.

Бүлэг 2 Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 21 ажил хийгдсэнээс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 3 ажил, харьцуулалтын аргаар 4 ажил нийт 546.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулж 7 ажилд 526.8 сая төгрөгийн гэрээ байгуулан 19.1 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан бөгөөд хэмнэлтийг дараагийн ажлыг санхүүжүүлэх журмаар зарцуулсан байна. /Хавсралт 6/

² Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.3.төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлж, түүнд үндэслэн аль ч шатны төсвийн эрх захирагч нь төсвийн тусгай шаардлагыг хангасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслөө зохиох;

7.4.Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүйгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, батлах болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхгүйгээр төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

³ Газрын тухай хуулийн 33.1.1. энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргана;

Засгийн газрын 68 дугаар тогтоолд заасны дагуу босго үнээс доош 14 ажилд шууд гэрээ байгуулан ажиллажээ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон бусад төсөл арга хэмжээний санхүүжилтээр хийгдэх ажлуудад тендер шалгаруулалтыг хийхдээ цахим сайтуудад тендерийн урилга болон тендерийн баримт бичгүүдийг нийтэлж ажилласан байна. Тендер шалгаруулахдаа ил тод шуурхай, хуульд заасан хугацаандаа багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулж ТБОНӨБАҮХАТ хуулийг мөрдөж ажилласан байна.

Бүлэг 3: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын 95% нь бүрэн хэрэгжиж дууссан байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдаж санхүүжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын хэрэгжилтийн явц 95 хувьтай байна. Нийт 21 ажил хийгдсэнээс 20 ажил нь бүрэн дуусан байна. Захиалагчийн хяналтыг захиалагч байгууллага болон ГХБХБГазар тавьж аймгийн СТСангийн хэлтсээс анхан шатны болон явцын хяналтыг үндэслэн үе шатны санхүүжилтийг хийжээ. Хэрэгжсэн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний ажлуудын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ нь ТБОНӨБАҮХАТХ-ын 5 дугаар бүлэгт заасны дагуу дараах ерөнхий болон тусгай нөхцлийг бүрэн тусгасан эсэхийг давтан тооцож үзэхэд: Хөрөнгө оруулалт хийгдэж гэрээ байгуулсан 21 ажлаас 15 ажлын гэрээнд төлбөр хийх, нөхцөл хэлбэрийг үе шаттай хийгдээгүй⁴, 7 ажилд захиалагчийн хяналтыг хийх талаар гэрээнд тусгагдаагүй⁵, 7 ажилд гүйцэтгэлийн баталгаа гаргах хугацаагүйгээр⁶ гэрээ байгуулсан байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 32 ажлыг 1,705.8 сая төгрөгөөр санхүүжүүлжээ. Үүнээс өмнөх оны 7 ажилд 766.5 сая төгрөг, урсгал зардлыг санхүүжүүлэхэд 53.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын ажлуудын бодит гүйцэтгэлийг үзэхэд:



Халиун сумын Олонбулаг багийн төвийн барилгын ажлыг “Харшийн цуурай” ХХК 25.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Зураг төсвийг “Барилгын зураг төсвийн товчоо” ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн бөгөөд бодит гүйцэтгэлийн үзэхэд: гадна хана цууралттай, өнгөлгөө оохор хийгээгүй байна⁷. Улсын комисс 2016 оны 06 дугаар сарын 06 өдөр хүлээн авсан байна.

⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.3.Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана: 40.3.1.гэрээний үнэ;

⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.3.Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана, 0.3.4.захиалагчийн хяналт болон бусад нөхцөл;

⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.3.Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана: 0.3.5.гүйцэтгэлийн баталгаа шаардах бол түүний дүн, хэлбэр;

⁷ Барилгын их засвар ажлын гүйцэтгэгч, захиалагчийн хяналт гүйцэтгэгчийн хооронд байгуулах гэрээний 4.1/Баталгаат хугацаанд /баталгаат хугацааг 3 жилээр тогтоо/ илэрсэн эвдрэл гэмтлийн актыг /байгалийн гамшиг, ашиглагчийн буруугаас бусад/ захиалагч, гүйцэтгэгч хамтран тогтоож буруутай талын хөрөнгөөр засуулна

Алтай сумын Цахилгааны эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр ОНХС-гаас 100.0 сая төгрөг, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 70.0 сая төгрөг нийтдээ 170.0 сая төгрөгөөр Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвтэй гэрээ байгуулсан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаас гаргасан 70.0 сая төгрөгөөр 70 ширхэг аккумулятор нийлүүлэгдэж, одоо бүрэн ажиллаж байгаа хэдий ч цэнэг муу хураадаг тул дутуу санхүүжүүлж ашиглалтанд хүлээн аваагүй байна.

Бусад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг үзэхэд ямар нэгэн эвдрэл, доголдолгүй сайн байна.

ОНТХО-аар 2016 онд хийгдсэн Шарга сумын Улаан тугийн багийн төвийн барилга-29,9 сая төгрөг, Халиун сумын Олонбулаг багийн төвийн барилга 25.0 сая төгрөг, Цогт сумын Далан багийн төв 39,9 сая төгрөг, Аймгийн ИТХ-д нийлүүлсэн авто машин 145,0 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын орон сууц 92.0 сая төгрөгийн хөрөнгийг НББ-д орлогод бүртгээгүй байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтын тайлангийн эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн байна. Дээрх хөрөнгө оруулалтын ажлуудыг нэгж харьяа байгууллагууд орлогод бүртгэх нь зүйтэй юм.

Өмнөх оны хөрөнгө оруулалтын талаар:

2013-2016 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 71 ажил хийгдсэн байна. үүнээс түүвэрчилэн 42 ажлыг бодит гүйцэтгэлийг газар дээр нь үзлээ. Чанар шаардлага болон барилгын тухай хуулийг зөрчсөн ажлуудыг дурьдвал:

1. 2015 онд “Орд Харш” ХХК гүйцэтгэсэн Хөхморьт сумын сангийн Далай багийн төвийн барилга нь суулт өгсөн цонх хана хагарсан байдалтай байна.

Өмнөх оны аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн аудитаар 11.8 сая төгрөгийг акт тогтоож, 748.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар өмнөх оны шийдвэрийн хэрэгжилтийг давтан тооцож үзэхэд:

1. Соёл амралтын хүрээлэнгийн 1-р багцын хашаажуулах ажлаас 59.1 м-р дутуу хашаажуулсан хайсны үнэ болох 11.8 сая төгрөгийн актыг барагдуулаагүй байна.
2. Соёл амралтын хүрээлэнгийн ажлын явц хангалтгүй, ажлыг эрчимжүүлэх хяналтыг үр дүнтэй тавьж ажиллах гэсэн албан шаардлага өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй зөрчлийг давтан 70 хувийн гүйцэтгэлтэй ажлыг улсын комисс хүлээн авсан байна.
3. Хөрөнгө оруулалтын үе шатны ажлуудад зохиогчийн хяналт тавьж баталгаажуулах талаар гэрээнд тусгаж, хяналтыг сайжруулах гэсэн албан шаардлага өгсөн боловч 2016 онд хийгдсэн гэрээ болон хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авах комисст зохиогчийг ажилуулаагүй байна.
4. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангаж ажиллах гэсэн албан шаардлага өгсөн боловч тайланд оны хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө, гүйцэтгэлийг

дутуу, хугацаа хоцорч оруулсан байна. үүнээс үзэхэд өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн хангалтгүй байна.⁸

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар:

Тайланд онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төсөв төлөвлөгөө гүйцэтгэлийг www.shilendans.gov.mn бүрэн мэдээлсэн эсэхийг давтан шалгаж үзэхэд нийт 21 ажлыг мэдээлэхээс 7 ажлын 1,137.0 сая төгрөгийн төсөвт өртөгийг мэдээлж санхүүжилт болон бусад ажлыг мэдээлээгүй байна. Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажилласан гүйцэтгэгчийн хувьд шилэн дансанд мэдээлэл байршуулдаггүй байна. Иймд цаашид гэрээний нэг нөхцөл болгон оруулж өгч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

IV БҮЛЭГ: ЗАСГИЙН ГАЗРААС ОЛГОСОН ВЕКСЕЛИЙН ҮР ДҮН

Бүлэг 1: Векселиэр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний сонголт оновчтой бодитой төлөвлөгдсөн эсэхийг үзэх боломжгүй байна

УИХ-ын 2016 оны 09 сарын 09-ны өдрийн 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн IV хавсралтад заасан эрх шилжсэн дараах 3 төсөл арга хэмжээний векселиэр санхүүжүүлэх дүн МУЗГ-ын 2016 оны 02 дугаар сарын 1-ны өдрийн 72 дугаар тогтоолоор батлагдсан дүнтэй зөрүүгүй таарч байна.

Хүснэгт №1: Векселиэр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээ 2016 он /сая төг/

Хүснэгт №2

№	Хуулийн код	Төсөл арга, хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	ЗГ-ын тогтоолоор	УИХ-ын тогтоолоор	Зөрүү	Гүйцэтгэгч
1	Век-Х.1.1.23	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Говь-Алтай, Алтай сум/	1,400.00	130	130	0	"Аксу Алтай" ХХК
2	Век-Х.1.1.30	Сургуулийн барилгын өргөтгөл /Говь-Алтай, Бугат сум/	1,586.60	459.3	459.3	0	"Уран охид" ХХК
3	Век-Х.1.1.35	Сургуулийн барилга, 640 суудал /Говь-Алтай, Баян-Уул сум/	3,581.60	334.8	334.8	0	"Урагшлах" ХХК
4	Век-Х.1.1.40	Сургуулийн барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум/	5,426.90	296.2	296.2	0	"Жинст транс" ХХК
5	Век-Х.1.1.41	Сургуулийн дотуур байрын барилга, гал тогооны хамт, 100 ор /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	1,000.00	281	281	0	"Аз Өрнөх" ХХК
6	Век-Х.1.1.46	Сургуулийн барилга, спорт заалын барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг, Эрүүл мэндийн шинжлэх ухааны	5,184.70	374	374	0	"Манхан Уст" ХХК

⁸ Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2 дахь заалт /төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд ажлаас халах санал хүргүүлэх заалттай хэдий ч хөрөнгө оруулалт хариуцаж байсан удирдлага албан тушаалтанд солигдсон тул хариуцлага тооцох боломжгүй байна.

		их сургуулийн харьяа анагаах ухааны коллеж/					
7	Век-Х.2.1.10	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/	1,087.40	189.8	189.8	0	"Хонгор буурал" ХХК
8	Век-ХIII.1.1.13	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2,898.90	240.7	240.7	0	"Лайт капитал хаус" ХХК
9	Век-ХIII.1.1.27	Өрхийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, Энх-Алтай өрхийн эмнэлэг/	450	95.1	95.1	0	"Харшийн цууриа" ХХК
10	Век-ХIII.1.1.37	Эмнэлгийн барилга, 10 ор /Говь-Алтай, Дэлгэр сум/	736.6	41.3	41.3	0	"Ус-Алтай" ХХК
11	Век-ХIV.1.16	Халиун-Цээл сумын 35 кВ-ын 31.4 км, 15 кВ-ын 84.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Говь-Алтай/	2,214.00	255.7	255.7	0	"Мон хас" ХХК
12	Век-ХIV.1.18	Тайширын усан цахилгаан станцын ажиллагсдын орон сууц, конторын барилга, халаалтын зуухны хамт /Говь-Алтай, Тайшир сум/	801.7	101.4	101.4	0	"Уран охид" ХХК
		НИЙТ ДҮН	26,368.4	2,799.3	2,799.3	0	

МУ-ын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, УИХ-ын 2015 оны 108 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, МУЗГ-ын 2015 оны 282 дугаар тогтоолуудад векселиэр санхүүжүүлэх ТАХ-г бүрэн тусгаж өгсөн байна.

Бүлэг 2: Векселиэр олгосон санхүүжилт, барилга угсралтын ажлын гүйцэтгэл бодитой, төлбөрийн эргэн төлөлт үндэслэлтэй байна.

Тайлбар: Говь-Алтай аймагт он дамжин хэрэгжиж байгаа 12 төсөл арга хэмжээнээс 3 ТАХ нь эрх шилжиж орон нутагт ирсэнтэй холбоотойгоор тухайн ажлуудын талаар уг бүлэгт оруулсан ба бусад эрх шилжээгүй ажлын талаар бүлгийн төгсгөл хэсэгт товч оруулсан.

Хүснэгт 2: Орон нутагт эрх шилжиж ирсэн ажлуудын гүйцэтгэлийг харуулав.

Хуулийн код	Төсөл арга хэмжээний нэр	Ажлын гүйцэтгэл /2017 оны 04 сарын байдлаар/	Хүлээн авсан эсэх
Век-Х.2.1.10	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/	100%	Хүлээж авсан
Век-Х.1.1.23	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Говь-Алтай, Алтай сум/	70%	Хүлээж аваагүй
Век-Х.1.1.41	Сургуулийн дотуур байрын барилга, гал тогооны хамт, 100 ор /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	100%	Хүлээж авсан

Векселиэр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хууль болон УИХ, ЗГ-ын тогтоолуудад тусгаж баталсан байна.

Дээрх 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг газар дээр нь очиж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/- Уг барилгын ажил зураг төсвийн дагуу хийгдсэн ба хэмжилт хийхэд зөрүүгүй байсан. Харин 2 давхарын зарим өрөөний таазнаас дусаал гоожсны улмаас паркетан шал овойж хөндийрсөн, зарим өрөөний паар хэсэг газраа задарсан, хананд зарим газраа хагаралт үүссэн. Мөн бохирын шугамд хөлдөлт үүссэний улмаас ашиглах боломжгүй болсон байна.

Зураг 1: Тайшир сумын Соёлын төвийн барилга




- Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Говь-Алтай, Алтай сум/-Уг барилгын ажлыг бодит байдал дээр очиж үзэхэд барилгын ажил зогссон, хүн орох боломжгүй байсан тул гадна талаас зургийг авч баримтжууллаа. Төсөл арга хэмжээг 2015 оны 07 сарын 15-ны өдрөөс эхэлж 2016 оны 08 сарын 28-ны өдөр ашиглалтанд оруулахаар тохиролцож гэрээ байгуулжээ. Гүйцэтгэгч тал гэрээг сунгах хүсэлт гаргасан боловч, одоо болтол сунгаагүй байна.

Зураг2: Алтай сумын Сургуулийн барилгын өргөтгөл 240 суудал



- Сургуулийн дотуур байрын барилга, гал тогооны хамт, 100 ор /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/-Уг барилгын ажлыг зураг төсөвтэй тулган талбайн хэмжилт хийхэд зөрүүгүй байсан. Харин барилгын дотор ханын замаск шавардлага нэлэнхүйдээ ховхорч хагаралт үүссэн байдалтай байлаа.

Зураг 3: Цогт сумын Баянтоорой тосгоны Сургуулийн дотуур байрны барилга



Хууль болон УИХ, ЗГ-ын тогтоолд заасны дагуу 2016 онд Тайшир сумын Соёлын төвийн барилгын ажилд 189.8 сая төгрөг, Алтай сумын сургуулийн барилгын өргөтгөлийн ажилд 130.0 сая төгрөг, Цогт сумын Баянтоорой тосгоны сургуулийн дотуур байрны барилгын ажилд 281.0 сая төгрөг нийт 600.8 сая төгрөгийг векселиэр санхүүжүүлсэн байна. Нийт санхүүжүүлсэн дүн, гэрээний дүнгээс хэтрээгүй байна.

Хүснэгт 3: Төсөл арга хэмжээний санхүүжилт /сая.төг/

Хүснэгт №3

Хуулийн код	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Нийт олгосон		Зөрүү
				Төрийн сангаар олгосон	Векселиэр олгосон	
Век-Х.2.1.10	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/	1,087.4	1,087.4	897.6	189.8	0
Век-Х.1.1.23	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Говь-Алтай, Алтай сум/	1,400.0	1,350.1	974.0	130.0	246.1
Век-Х.1.1.41	Сургуулийн дотуур байрны барилга, гал тогооны хамт, 100 ор /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	1,000.0	990.0	700.9	281.0	0

Дээрх 3 ТАХ-ны үлдэгдэл санхүүжилтийг векселиэр олгохдоо вексель бичих дүнг нэмж бичсэн байна.

Векселиэр санхүүжсэн ажлуудын ажил гүйцэтгэх гэрээнд хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг батлагдсан төсөвт өртгөөс зөрүүтэй тусган, ТЕЗ-тай тооцоо нийлээгүй төвлөрүүлээгүй байна. Тухайлбал:

- Векселиэр санхүүжсэн эрх шилжсэн 3 төсөл арга хэмжээний захилагчийн хяналтын зардлыг тооцож үзвэл: Тайшир сумын Соёлын төвийн 18.4 сая төгрөг БСШУЯ-аас суутгагдан Барилгын хөгжлийн төв рүү шилжүүлсэн ба, Алтай сумын 240 хүүхдийн Сургуулийн барилгын хяналтын зардал 8.0 сая төгрөгийг санхүүжилтээс суутгасан боловч хяналт тавих эрх бүхий ГХБХБГ-руу шилжүүлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290-р тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.19-т “Захиалагч барилгын ажлын зардал, техник, эдийн

засгийн үндэслэл/ТЭЗҮ/, зураг төслийн үнэ, техник хяналтын зардал нормчиллын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ” БХБ Сайдын 2015 оны 4 сарын 10-ны 1/1085 тоот тушаалыг зөрчсөн байна.

- Зураг төсвийг зардлыг гүйцэтгэгч, зураг төсөв боловсруулсан гүйцэтгэгчтэй хоорондын гэрээ байгуулан зураг төсвийн үнийг шилжүүлсэн байна.
- Тайшир сумын Соёлын төвийн барилгад магадлашгүй ажлын акт гарган үйлдсэн бөгөөд Алтай сумын Сургуулийн барилгад магадлашгүй ажлын акт үйлдээгүй, ажил дуусаагүй, хэрэгжилт дутуу байна.

Дээрх ажлуудын хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг харьцуулж үзвэл: 1,087.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Тайшир сумын Соёлын төвийн барилгын ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчийн хяналтыг 18.4 сая төгрөгөөр, магадлашгүй ажлын зардлыг 9.9 сая төгрөгөөр тусгасан байхад 1,400.0 сая төгрөгийн өртөгтэй Алтай Сургуулийн барилгын өргөтгөлийн ажил гүйцэтгэх гэрээнд захиалагчийн хяналтын зардлыг 1.1 сая төгрөгөөр, магадлашгүй ажлын зардлыг 1.1 сая төгрөгөөр тусгаж гэрээ байгуулсан нь харилцан адилгүй байна.

Иймд байгуулсан гэрээний үнийн дүнг, батлагдсан төсөвт өртөгтэй тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 4: Батлагдсан төсөвт өртөг, байгуулсан гэрээ /сая.төг/

хүснэгт №4

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн /сая төг/					Батлагдсан төсөвт өртөг					Зөрүү				
			Улсын төсвөөс	Захиалагчийн хяналтын зардал	Зураг төсвийн үнэ	магадлашгүй ажил магадлашгүй ажил	Гэрээний үнэ	Улсын төсвөөс	Захиалагчийн хяналтын зардал	Зураг төсвийн үнэ	магадлашгүй ажил магадлашгүй ажил	нийт дүн	Улсын төсвөөс	Захиалагчийн хяналтын зардал	Зураг төсвийн үнэ	магадлашгүй ажил магадлашгүй ажил	дүн
1	Соёлын төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/	1,087.40	1,044.90	18.40	14.19	9.90	1,087.39	1036.8	18.4	14.19	18	1087.39	8.10	-	-	(8.10)	
2	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Говь-Алтай, Алтай сум/	1,400.00	1,347.80	1.10		1.10	1,350.00	1,295.45	23.5	19.3	11.75	1,350.00	52.35	(22.40)	(19.30)	(10.65)	
3	Сургуулийн дотуур байрын барилга, гал тогооны хамт, 100 ор /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	1,000.00	962.50	8.00	19.50		990.00	962.5	8	19.5		990	-	-	-	-	
	НИЙТ ДҮН	3,487.40	3,355.00	27.5	33.65	10.98	3,427.50	3,355.00	27.5	33.65	10.98	3,427.50	60.45	(22.40)	(19.30)	(18.75)	

Эрх шилжээгүй бусад ажлын талаар:

1. Бугат сумын сургуулийн барилгын өргөтгөлийн барилга: Тухайн ажил нь 1,586.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд Улсын төсвөөс 2013-2016 онд 958.3 сая төгрөг, 2016 онд векселиэр 459.3 сая төгрөг нийт 1,417.6 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ. Бодит байдал дээр үзэхэд ажлын гүйцэтгэл 85%-90%-тай байна.
2. Баян-Уул сумын 640 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга: Уг ТАХ нь 3,581.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд Улсын төсвөөс 2010-2016 онд 2,654.7 сая төгрөг, 2016 онд векселиэр 334.8 сая төгрөг нийт 2,989.5 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ. Бодит байдал дээр ажлын гүйцэтгэлтэй танилцахад хэрэгжилт 100% буюу бүрэн хэрэгжиж ашиглалтанд хүлээн авсан байна.
3. Есөнбулаг сумын 640 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга: Уг ТАХ нь 5,426.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд Улсын төсвөөс 2015-2016 онд 1,703.8 сая төгрөг, 2016 онд векселиэр 296.2 сая төгрөг нийт 2,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ. Бодит байдал дээр ажлын гүйцэтгэлтэй танилцахад хэрэгжилт 50%-тай байна.

4. Есөнбулаг, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн харьяа анагаах ухааны коллежийн 960 суудалтай Сургуулийн барилга, спорт заалын барилга: Уг ТАХ нь 5,184.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд Улсын төсвөөс 2015 онд 546.7 сая төгрөг, 2016 онд векселиэр 374.0 сая төгрөг нийт 920.7 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ. Бодит байдал дээр ажлын гүйцэтгэлтэй танилцахад хэрэгжилт 50%-тай байна.
5. Есөнбулаг сумын 50 ортой төрөх эмнэлэг: Тус ажил нь 2,898.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд Улсын төсвөөс 2011-2016 онд 2,433.0 сая төгрөг, 2016 онд векселиэр 165.6 сая төгрөг нийт 2,598.6 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ. Бодит байдал дээр ажлын гүйцэтгэлтэй танилцахад хэрэгжилт 45%-тай байна. Гэтэл санхүүжилтийн 90%-ийг авсан байна.
6. Есөнбулаг сум, Энх-Алтай өрхийн эмнэлгийн барилга: Уг ТАХ нь 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ба векселиэр 2015 онд 354.9 сая төгрөг, 2016 онд 95.0 сая төгрөг нийт 450.0 сая төгрөгийг бүрэн авч, бодит гүйцэтгэл 100% буюу одоогоор ашиглаж байна.
7. Дэлгэр сумын 10 ортой эмнэлгийн барилга: Уг ТАХ нь 736.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд Улсын төсвөөс 2012-2014 онд 499.78 сая төгрөг, 2014-2016 онд векселиэр 233.5 сая төгрөг нийт 733.3 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Бодит гүйцэтгэл 100% одоогоор ашиглаж байна.
8. Халиун-Цээл сумын 35 кВ-ын 31.4 км, 15 кВ-ын 84.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц: Уг ТАХ нь 2,214.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ба 2012-2014 онд 1,923.3 сая төгрөг, 2016 онд векселиэр 255.7 сая төгрөг нийт 2,179.0 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Бодит гүйцэтгэл 100% одоогоор ашиглаж байна.
9. Тайширын сумын усан цахилгаан станцын ажиллагсдын орон сууц, конторын барилга, халаалтын зуухны хамт: Төсөвт өртөг 801.7 сая төгрөг, 2013-2014 онд 700.3 сая төгрөг, 2016 онд векселиэр 101.4 сая төгрөг нийт 801.7 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Бодит байдал дээр гүйцэтгэл 100% одоогоор ашиглаж байна. / Хавсралт № 8/

Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр ашгийн илрүүлэлт:

1. Бигэр суманд баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг улсын комисс хүлээн авахдаа гадна орчны бетон зам, тоглоом, дотор цэвэр бохирын холболт зэрэг 26.8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байхад хүлээн авсан байна.
2. Соёл амралтын хүрээлэн багц 3-ын дагуу хийх ажлын гүйцэтгэл 60 хувьтай буюу 70.4 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад төсөл арга хэмжээний ажлыг улсын комисс хүлээн авсан авч 2017 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хүртгэл нэмэлт гэрээ байгуулсан байна.
3. Соёл амралтын хүрээлэнгийн багц -2 хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлийг давтан тулгаж үзэхэд: Хогийн сав -16 ширхэг, сандал -29 ширхэг, худалдаа үйлчилгээний саравч-17 ширхэг, харуулын байр-18 ширхэг ажлуудыг дутуу хийгдсэн байхад Улсын комисс хүлээн авсан байна.
4. Хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагч, гүйцэтгэгчтйн хяналт хангалтгүй байна. Мөн соёл амралтын хүрээлэнгийн багц 3 ажлын гүйцэтгэл 60 хувьтай буюу 70.4 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад улсын комисс хүлээн авч нэмэлт гэрээ байгуулжээ. Хөрөнгө оруулалтын ажлуудад захиалагчийн хяналт хангалтгүй байгаа, бүрэн хийгдэж дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах зэргээс тухайн ажлын чанар байдал, үр дүнг хүртэх хугацаа, үр ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсч байна.
5. Цогт сумын Баянтоорой тосгоны Сургуулийн дотуур байрны барилгын дотор талын ханын замаск шавардлага ховхорч хагаралт үүссэн, Тайшир сумын Соёлын төвийн барилгын 2 давхарын зарим өрөөний таазнаас дусаал гоожсны улмаас паркетан шал овойж хөндийрсөн, зарим өрөөний паар хэсэг газраа задарсан, хананд зарим

газраа хагаралт үүссэн, Хөхморьт сумын ЭМТ-ийн барилгын засварын гадна талын засвар нь баруун талаасаа хууларсан, Дэлгэр сумын Гуулин тосгоны ЭМТ-ийн барилгын засвар нь хана хагарч, мөөгөнцөртсөн Соёл амралтын хүрээлэнгийн багц 4 ажлын тухайд 4 тоглоом хийснээс морин тойруулгын морь байхгүй, 1 алсын харагч байхгүй, Төгрөг сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын 5 цонх дотор талдаа цууралт өгсөн, таазны хавтан хооронд зааг гарсан, Халиун сумын Олонбулаг багийн төвийн гадна хана цууралттай, өнгөлгөө оохор хийгээгүй, Хөхморьт сумын сангийн далай багийн төвийн хана тааз цуурсан, суулт өгсөн байна. мөн соёл амралтын хүрээлэн байгуулах ажлын хөл бөмбөгийн талбай, гар бөмбөг, теннис, хоккей тэшүүр талбай, сурын талбай зэрэг ажлуудын чанар байдалтай танилцахад гар бөмбөгийн талбайн резинен наалт байхгүй, цементэн талбайн зах хэсгээр хайрга нь гарсан байдалтай байна.

6. Улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээгээр хийгдэж буй 9 ажлын захиалагчийн хяналтын зардал 134.0 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг холбогдох байгууллагад шилжүүлээгүй байна.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 2016 онд эрх шилжиж ирсэн Тайшир сумын 75 ортой хүүхдийн цэцэрлэг 857.9 сая төгрөг, Алтай сумын 240 хүүхдийн сургуулийн өргөтгөл 1,350.0 сая төгрөг, Хүүхэд залуучуудын ордны барилга 2,761.9 сая төгрөг, Соёл амралтын хүрээлэн байгуулах багц-3 ажил 176.0 сая төгрөг нийт 5,145.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажил хийгдэж дуусаагүй ба ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.
8. Төсвийн тухай хуулиар хэрэгжих 12 барилгын ажлын зураг төсвийн магадлалын ерөнхий дүгнэлт хийсэн байдлыг тулгахад 3 барилгын 1,956.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зураг төсөвт магадлал дүгнэлт гаргуулаагүй байна.
9. Соёл амралтын хүрээлэн байгуулах ажлаар Ус-Алтай ХХК-ний хийсэн 1,099.2 сая төгрөгийн 2 ажлыг НББ-д орлогоор бүртгээгүй байна.
10. Хөрөнгө оруулалтаар хийхээр гэрээ байгуулсан 21 ажлаас 15 ажлын гэрээнд төлбөр хийх, нөхцөл хэлбэрийг үе шаттай тусгаагүй, 7 ажилд захиалагчийн хяналтыг хийх талаар заалт байхгүй, 7 ажилд гүйцэтгэлийн баталгаа гаргах хугацаагүйгээр гэрээ байгуулжээ.

Засгийн газраас олгосон векселээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний илрүүлэлт


1. Векселиэр 2016 онд санхүүжсэн Цогт сумын Баянтоорой тосгоны Сургуулийн дотуур байрны барилгын / гал тогооны хамт 100 ор / хяналтын зардал 8.0 сая төгрөгийг хяналт тавьж ажилласан холбогдох хяналт тавьсан байгууллагад олгоогүй байна.
2. Алтай сумын 240 хүүхдийн Сургуулийн барилгын өргөтгөлийн ажлын батлагдсан төсөвт хяналтын зардлыг 23.5 сая төгрөгөөр, магадлашгүй ажлын зардлыг 11.7 сая төгрөгөөр тооцсон байхад ажил гүйцэтгэх гэрээнд хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг тус бүр 1.1 сая төгрөгөөр тооцож гэрээ байгуулсан байна.
3. Векселиэр 2016 онд санхүүжсэн Алтай сумын 240 хүүхдийн Сургуулийн барилгын өргөтгөлийн ажил нь санхүүжилттэй холбоотойгоор хэрэгжиж дуусаагүй, тухайн байгууллага гэрээ сунгах хүсэлт гаргасан боловч сунгалт хийгдээгүй гэрээг шинэчлэн байгуулаагүй байна. Векселиэр 2016 онд санхүүжсэн.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: 2008-2015 онуудад хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудаас аймгийн хэмжээнд нийт 10 ажлын гүйцэтгэл дунджаар 61 хувьтай, ажлын гүйцэтгэл хангалтгүй байна. Жишээ нь: Аврах гал унтраах ангийн барилга нь 1,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2013-2015 онуудад 1,499.71 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Үлдэгдэл санхүүжилт 100.29 сая төгрөг байтал барилгын ажлын гүйцэтгэл 55-65 хувь зөвхөн 3 давхарын өрөг боссон байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: 2008-2015 онуудад хэрэгжиж байгаа эрх шилжээгүй 4 хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нь анх баталсан дүнгээс 3,667.9 сая төгрөгөөр, эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын 2 ажлын хувьд 1,270.3 сая төгрөгөөр нийтдээ 4,938.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын ажил он дамжин удааширсанаас барилгын чанар, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Жишээ нь: Баян-Уул сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын дотор дээвэр муу хийсэнээс таазнаас ус гоожиж ховхорч хууларсан, Ардын дуу бүжгийн Алтай чуулгын тухайд гадна талын хана нэлэнхүүдээ цууралт өгөн хана товойж нурах магадлалтай, шинэ сум төслийн хүрээнд 3,490.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан хэдий мэргэжлийн байгууллагын зүгээс дүгнэлт гаргаж өгөх боломжгүй гэсэн тайлбарыг өгсөн бөгөөд бүрэн хийгдэж дууссан ажил байхгүй, Хүүхдийн ордны барилгын цонх хагарсан, хажуу хана руу ус орсон зэргээр чанар байдалд нь сөрөг нөлөө үзүүлсэн байдалтай байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРСЭН САНАЛ

Тухайн байгууллагын санал	Саналд өгсөн хариу
Алтай хотын Соёл амралтын хүрээлэн барьж байгуулах ажлын Багц-3 буюу Усан оргилуур, усан хангамжийн ажил нь хугацаандаа багтаагүй ч орох санхүүжилт татагдах байсан тул орон нутгийн эрх ашгийн үүднээс 2016 оны 11 сарын 30-ний өдөр улсын комисс ажиллан нэмэлт гэрээ байгуулсан. Нэмэлт гэрээний хугацаа 2017 оны 05 сарын 27-ний өдөр дуусна. ГХБХБГ-ын 2017 оны 03 дугаар сарын 29-ний 126 тоот албан бичгээр 2017 оны 04 сарын 20-ний дотор барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлөө авч барилга, угсралтын ажлаа гүйцэтгэх тухай "Ус-Алтай" ХХК-д мэдэгдэл хүргүүлсэн байна.	Бүрэн хийгдэж дуусаагүй ажлын хүлээн авсан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Аймгийн засаг даргад зөвлөмж хүргүүллээ.
Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 126 дугаар тушаалаар батлагдсан барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохицуулах журмын 1 дүгээр ангилалд орж буй Бугат, Чандмань сумдын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгад магадлал хийх шаардлагагүй юм.	Дээрх саналын дагуу Бугат сумын ЭМТ болон Чандмань сумын ЭМТ-ийн их засврын зураг төсвийг магадлал хийх шаардлагагүй гэж үзэн зөрчлөөс хаслаа.



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ
УДААШИРАЛТАЙ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНД ТАВИХ
ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР